



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН ЯАМ**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,  
Утас: 26-22-27, Факс: (976-11) 323589  
E-mail: info@mecss.gov.mn, http://www.mecss.gov.mn

2020.03.12 № 2/1419  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тодруулга хүргүүлэх тухай**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас 2020 оны 02 дугаар сарын 14-ны өдөр зарласан "Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад суурин компьютер нийлүүлэх" тендерт оролцогчоос дараах тодруулга ирүүлжээ. Үүнд:

1. <<2018, 2019 онд гүйцэтгэсэн ижил төстэй дор хаяж нэг удаагийн гэрээний үнийн дүн нь санал болгож буй үнийн дүнгийн 80 хувиас багагүй байна. Үүнийг ижил төстэй 1-с олон гэрээний үнийн дүнгийн нийлбэрээр тооцож болох уу?>> гэсэнд: Ижил төстэй хийж гүйцэтсэн ажлуудаас дор хаяж 1 гэрээний үнийн дүн нь санал болгож буй үнийн дүнгийн 80 хувиас багагүй байна гэж ойлгоно.
2. <<Тухайн төрлийн бараа нийлүүлэх тусгай зөвшөөрөл шаардлагатай гэсэн байна. Үүнийг гадаад худалдаа эрхлэх зөвшөөрөл гэж ойлгож болох уу?>> гэсэнд: Оролцогч нь гадаад худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд тухайн чиглэлээр бараа нийлүүлэх үйл ажиллагаа явуулдаг байна гэж ойлгоно.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,  
ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Л.ЦЭДЭВСҮРЭН

